



МОНГОЛ УЛС
ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2022 оны 08 сарын 25 өдөр

Дугаар А/429

Хэрлэн сум

Төсөл сонгон шалгаруулалтыг ил тод
явуулахад хөрөнгө зарцуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3, Нийтийн мэдээллийн ил тод байдлыг хангах тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.4.26, Сангийн сайдын 2021 оны 61 дүгээр тушаалаар батлагдсан "Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам"-ын 2 дугаар зүйлийн 2.1.5 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Ажлын байр шинээр бий болгох, хадгалах, хамгаалах зорилготой "Аж ахуй эрхлэгчдийг дэмжих хөтөлбөр"-т хамрагдах хүсэлтэй иргэдийн төслийг нээлттэй, ил тод сонгон шалгаруулах, олон нийтийн мэдээллийн хэрэгслээр сурталчлах үйл ажиллагааны зардалд 1,300,000 (Нэг сая гурван зуун мянга) төгрөгийн хөрөнгө зарцуулсугай.

2.Хөрөнгө зарцуулалтын тооцоог хавсралтаар баталсугай.

3.Дээрх зардалд шаардагдах хөрөнгийг Засаг даргын нөөц сангийн урьдчилан төлөвлөж төсөвт тусгах боломжгүй нэг удаагийн шинжтэй арга хэмжээний зардлаас санхүүжүүлэхийг аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга (Ж.Ганбаатар)-д, захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын орлогч (Л.Батсайхан)-д тус тус даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Ц.ЧОГСОМЖАВ



Аймгийн Засаг даргын 2022
оны дугаар сарын ...-ны
захирамжийн хавсралт

ЗАРДЛЫН ТООЦОО

№	Зардлын нэр	Тоо ширхэг	Нэгж үнэ	Нийт үнэ
1	Материалын зардал	1	1,300,000	1,300,000